

“МОНГОЛ ДАХЬ СОЛОНГОСЫН ТҮҮХИЙН СУДАЛГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ”

Ц.Цэрэндорж

ШУА-ийн Түүх, Археологийн Хүрээлэн

Доктор (Ph.D)

Монгол, Солонгос хоёр улс нь эрт цагаас өргөн дэлгэр харилцаж, бие биеийнхээ хэл, түүх, соёлыг судалсаар олон зуун жилийг үджээ. 995 онд Корйё улсаас Монгол угсааны Хятан улсад хятан хэл сургахаар 10 хүүхдийг илгээж байсан нь Солонгос дахь Монгол судлалыг гэрчлэн харуулах одоогоор олдоод буй хамгийн эртний баримт билээ. Монгол дахь Солонгос судлал ч үүнээс дутахгүй урт түүхтэй нь илэрхий.

Монгол-Солонгосын харилцаа дундад зууны үед буюу XIII-XIV зууны үед маш эрчимтэй хөгжиж байлаа. Энэ үед хоёр орны хооронд улс төр, эдийн засаг, соёл гэх мэт олон салбарын харилцаа нэн эрчимжиж, харилцан нөлөөлж байсныг эрдэмтэн судлаачид нэгэнт судлан тогтоосон билээ.

Гэвч Хятадыг эзлэн ноёрхож байсан Монголын Юань улсын эрх баригчид эх нутагтаа эргэн ирж, Солонгосын хойгт Корйё угсааны хаанчлалыг түлхэн унагаж, Чосонь улс байгуулагдсанаас хойш Монгол, Солонгосын харилцаа өмнөх үеийг бодвол саарч эхэлсэн юм.

Монгол, Солонгосын харилцаа дундад зууны үеэс хойш олон зуун жил тасарч байгаад саяхнаас сэргэсэн гэсэн ойлголт зарим судлаачдын дунд, ялангуяа олон нийтийн хүрээнд хүчтэй байгааг засч залруулах цаг нэгэнт болжээ. Өгүүлэн буй үед хоёр орны харилцаа нэлээд саарснаас бус, огт ул мөргүй тасарсан зүйл ерөөс байхгүй билээ.

Харилцаа ийнхүү саарсан нь нэг талаас Монгол, Чосонь хоёр улс шууд хил савлахаа больсон, нөгөө талаас Чосонь-ий эрх баригчид гадаад бодлогын талаар Хятадын Мин улсын талыг тууштай баримталж, Монголтой аль болох зайнаас харилцах болсон, мөн шинэ күнзийн суртлыг төрийн суртал болгож “чжунхуа” буюу нанхиадын соёлыг онцгой дээдлэн, түүхэнд Хятадыг эзлэн ноёрхож байсан умардын нүүдэлчдийн төр улсуудын соёлыг үзэн ядах, долж цэрвэх хандлага хүчтэй байсантай холбоотой. Гэвч энэ үед хоёр орны харилцаа бүр тасарсангүй, бага боловч харилцааар байсан нь түүхийн сурвалж бичгийн мэдээ баримтаас тодорхой харагддаг. Тухайлбал, Чосонь улсын үед Са-Йөгвонь (사역원, 司譯院) хэмээх орчуулгын хүрээлэнг үргэлжлүүлэн хятад, зүрчид (манж), япон хэлний хамт монгол хэлийг зааж байсан нь “хөх морин жилийн шинэтгэл” буюу 1894 он хүртэл үргэлжилсээр байжээ. Ийнхүү Чосонь-д

монгол хэлийг заасаар байсан нь хоёр орны хооронд харилцаа бүрмөсөн тасраагүй байсныг харуулахын зэрэгцээ, энэ харилцаа хэзээ нэгэн цагт дахин идэвхжиж, сэргэнэ гэсэн таамаглал Чосонь-ий талд байсныг гэрчилнэ. Өөрөөр хэлбэл, монголчууд Их Юань улсын адил дахин хүчирхэгжиж, Чосонь улстай харилцана гэсэн үзэл бодол монголчууд нэлээд хүчирхэг байсан XV-XVII зууны үед төдийгүй, бүр Манж Чин улсын эрхшээлд бүрэн орж, доройтсон XVIII зууны сүүл үе хүртэл Чосонь-ий эрх баригчдад гүн бат оршиж байсныг түүх сурвалжийн мэдээ занги гэрчилдэг.

Манжийн эрхшээлийн үед төр засгийн хэмжээний харилцаа тасарсан боловч, монгол, солонгосчууд харилцсан, харилцан зорчсон, худалдаа наймаа хийсэн тухай мэдээ баримт багагүй бий. Ямар ч атугай харилцаа тасралгүй, их бага хэмжээгээр үргэлжилсээр XX зууны эхэнтэй золгожээ. Өнгөрсөн зуунд Монгол-Солонгосын харилцаа төр засгийн төвшинд дахин сэргэж, олон талаар гүнгийрч байгаа нь энэ үеийн харилцааны гол онцлог юм. Ялангуяа Монгол улс 1990 онд БНСУ-тай албан ёсны дипломат харилцаа тогтоосноор солонгос хэл, Солонгосын түүх, соёлыг сонирхон судлах явдал урьд байгаагүйгээр нэмэгдэж, Монголын Солонгос судлал хөгжлийн шинэ шатанд гарсан билээ.

Тус өгүүлэлд Монгол улс дахь Солонгосын түүхийн судалгааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, хэтийн төлөв зэрэг асуудлыг тоймлон өгүүлэхийг зорив.

1990 оноос өмнөх Солонгосын түүхийн судалгаа

Солонгосын түүхийг судалсан судлаачдын бүтээлийг 2 үндсэн бүлэгт зааглан хэлэлцэж болно.

Нэгдүгээрт, Солонгосын түүхийг тусгайлан судалсан бүтээл

Хоёрдугаарт, Монголын болон бус нутгийн түүхийн судалгааны хүрээнд дам хөндөн судалсан бүтээл

Солонгосын түүхийн талаар анхлан дурдсан бүтээл бол А.Амарын “Монголын товч түүх” юм. Түүнээс хойш “БНМАУ-ын түүх” 1, 3 ботнудад Солонгосын тухай өгүүлэхдээ голчлон Монголын эзэнт гүрний байлдан дагууллын явцад Солонгосыг хэрхэн эзэлсэн, тухайн үеийн Монгол-Солонгосын харилцаа, Юань улсын зүгээс явуулсан Японыг эзлэх аян дайны талаар товч дурдсан байна. Гэвч тухайн үед солонгос хэлийг сайтар эзэмшсэн судлаач, ялангуяа мэргэжлийн түүхч ховор байсан тул түүхийн сурвалж бичгийг ашиглаж чадалгүй, Зөвлөлтийн эрдэмтдийн судалгааг дам ашиглаж байжээ.

Монголын түүхийг судлахдаа “Корйөса” тэргүүтэй солонгос сурвалжийг хамгийн анх ашигласан хүн бол доктор Ч.Далай юм. Тэрээр “Юан гүрний

үеийн Монгол” хэмээх ганц сэдэвт зохиолдоо Японыг эзлэх аян дайны талаар өмнөх зохиолуудаас илүү тодорхой өгүүлснээс гадна, “Корйоса”-д Юань гүрний талаарх чухал тэмдэглэл, ялангуяа тухайн үеийн Монгол-Корйогийн харилцааг тодруулах эх хэрэглэгдэхүүн агуулагдаж байна гэж дүгнэсэн байдаг.¹

1960-аад оны эхээр Солонгос судлалаар мэргэжсэн анхны боловсон хүчин бэлтгэгдсэнээр 1960-аад оны сүүл үеэс Солонгосын түүхийг тусгайлан судалсан анхны зохиолууд гарч эхэлжээ.

БНАСАУ-д солонгос хэлний мэргэжлээр их сургууль дүүргэсэн эрдэмтэн Б.Сумьяабаатар “Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд”², “XIII-XIV зууны Монгол-Солонгосын харилцааны бичгүүд (Тэргүүн дэвтэр)”³ хэмээх нэгэн сэдэвт зохиолуудаараа Монгол дахь Солонгос судлалын үндсийг тавьсан билээ.

Профессор Б.Сумьяабаатар багштан “Монгол, солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд” хэмээх зохиолдоо монгол, солонгос 2 угсаатны эртний түүхэн харилцаа, эртний солонгос аймаг улсууд, Төв Азийн нүүдэлчдийн хэлхээ холбоог нарийвчлан судалж, өвөрмөц саналуудыг дэвшүүлсэн нь эдүгээ ч эрдэм шинжилгээний ач холбогдлоо алдаагүй байна.

Мөн “XIII-XIV зууны Монгол-Солонгосын харилцааны бичгүүд” хэмээх зохиолдоо Чингис хаан болон түүнийг залгамжлагч хаадаас Корйё улсын вангуудтай 1219-1254 оны хооронд харилцсан захидал харилцааны бичиг, түүхэн баримт сэлтийг монгол хэлээр орчуулан, сурвалжийн мэдээтэй харгуулан тулгаж, эрдэм шинжилгээний зүүлт тайлбар хийж хэвлүүлсэн нь мэргэжлийн судлаачдын зүгээс өндөр үнэлэлт авдаг билээ.

1990 оноос өмнөх Солонгосын түүхийн судалгааны байдлыг тоймлон хэлбэл, ганц нэг судлаачийн бүтээлийг эс тооцвол судалгааны явцад дашрамд дурдах, гаднын судлаачийн ном зохиолоос орчуулан хэрэглэхээс хэтрэхгүй байжээ.

1990 оноос хойших Солонгосын түүхийн судалгаа

1990 оноос эхлэн Монгол улс ардчиллын замаар замнаж эхлэхийн хамтаар БНСУ-тай дипломат харилцаа тогтоосноор улс төр, эдийн засаг, соёлын харилцаа өргөжин хөгжсөөр өнөөг хүрлээ. БНСУ-тай нийнхүү өргөн харилцаж эхэлсэн нь Монгол дахь Солонгос судлалыг шинэ шатанд гаргах боломжийг бүрдүүлсэн юм. Солонгос хэл, соёлыг сонирхон судлагчдын тоо эрс өсөхийн

¹ Ч.Далай, Юань гүрний үеийн Монгол, УБ., 1973.

² Б.Сумьяабаатар, Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд, УБ., 1975.

³ Б.Сумьяабаатар, XIII-XIV зууны Монгол-Солонгосын харилцааны бичгүүд (Тэргүүн дэвтэр), УБ., 1978.

хамтаар Солонгосын түүхийн судалгаанд тоо, чанарын өөрчлөлт гарч эхлэв.

Энэ үеэс эхлэн Монгол, Солонгосын эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагаа идэвхжсэн нь урьд орно нь олж үзэхэд бэрхшээлтэй байсан ном судрыг олж үзэх, ялангуяа БНСУ-д гарсан судалгааны бүтээлтэй танилцах өргөн боломжийг нээв. Тухайлбал, профессор Б.Сумьяабаатар Даньгүг их сургуульд зочин багшаар ажиллахдаа өөрийн бүтээлээ нэмж засварлан, дахин хэвлүүлсэн байна.⁴

Мөн судлаач Б.Лхагва “XIII-XIV зууны Монгол, Солонгосын харилцааны онцлог шинж, харилцан нөлөөлөл, түүний ул мөр” сэдвээр 1995 онд докторын зэрэг хамгаалсан нь Монголд Солонгосын түүхтэй холбоотой сэдвээр зэрэг хамгаалсан 2 дахь хүн болж байгаа юм. Доктор Б.Лхагва диссертациа хожим нь “Монгол-Солонгосын харилцааны уламжлалаас” хэмээх нэгэн сэдэвт зохиол болгон хэвлүүлсэн нь дундад зууны үеийн Монгол-Солонгосын харилцааг туушид нь авч үзсэн анхны бүтээл болсноороо чухал ач холбогдолтой болжээ.⁵

Түүнчлэн академич Ч.Далай хятад, монгол, солонгос түүхийн сурвалжид тулгуурлан, тусгай товхимол туурвиж, Монгол, Солонгосын эрт, дундад үеийн түүхэн харилцааг шинээр үнэлж дүгнэхийг оролджээ.⁶

1990-ээд оноос хойш Монгол дахь Солонгос судлалын түүхэнд гарсан онцгой үзэгдэл бол солонгос хэлний мэргэжилтэй боловсон хүчнийг эх орондоо бэлтгэж эхэлсэн явдал агаад тэдний зарим нь Солонгосын түүхийн чиглэлээр магистр, докторын зэрэг хамгаалж, Солонгосын түүхийн судалгаанд ихээхэн хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, МУИС-ийн багш Ж.Баттөр 2000 онд “XX зууны Монгол, Солонгосын харилцааны зангилаа асуудлууд (1910-1950)” сэдвээр түүхийн ухааны докторын зэрэг хамгаалснаас гадна шинэ үеийн Монгол-Солонгосын харилцааны түүхийн чиглэлээр нэгэн сэдэвт зохиол, өгүүллтийн эмхтгэл⁷ туурвисан байна. Тэрээр нэгэн сэдэвт

⁴ 수미야바야타르, 中世韓蒙關係史-文獻篇, 개정중보판, 단국대학교출판부, 1992.

⁵ Б.Лхагва, Монгол-Солонгосын харилцааны уламжлалаас, Соул, 1996.

⁶ Ч.Далай, Монгол, Солонгосын эртний түүхэн харилцаа, УБ., 1998.

⁷ Ж.Баттөр, XX зууны Монгол Солонгосын харилцаа, Тэргүүн дэвтэр (1910-1930-аад он), УБ., 2000;

Ж.Баттөр, XX зууны Монгол Солонгосын харилцаа, Дэд дэвтэр (1948-1961), УБ., 2004; Ж.Баттөр, Хан улсын түүх хэмээх нэгэн эх бичгийн судалгаа, УБ., 1996; Ж.Баттөр, Солонгос судлалын өгүүллүүд, тэргүүн, дэд дэвтэр, УБ., 2002.

Ж.Баттөр, 1920-1940-өөд оны Монголын хэвлэлд Солонгосын тухай өгүүлсэн нь- Монгол, Солонгосын хамтарсан 2-р эрдэм шинжилгээний хурал, УБ., 2001; Ж.Баттөр, Солонгосын дайны үеийн Монгол ба Умард Солонгосын харилцаа- Монгол, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 10 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2000; Ж.Баттөр, Солонгосчуудаас Богд хаанд ирүүлсэн захидлын тухайд - Монгол, Солонгосын хамтарсан 3-р эрдэм шинжилгээний хурал, УБ., 2001; Ж.Баттөр, Монголын түүхэн дэх Солонгосын нмиж- МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн эрдэм шинжилгээний бичиг, Боть 245 (24)- Түүх (IV), УБ., 2005; Ж.Баттөр, Дундад үеийн Монголын түүх бичлэгт гарах Солонгосын тухай мэдээ баримтууд - Монгол улс, БНСУ-тай

зохиолынхоо тэргүүн дэвтэрт 1911-1930-аад оны хооронд Монголын Нийслэл хүрээнд ажиллаж, амьдарч байсан, Монголоор дайран өнгөрөхдөө тус улсын эрх баригчидтай уулзаж ярилцаж байсан солонгос хүмүүсийн дуртгал, аян замын тэмдэглэл, захидал харилцааны бичиг, Монголын архивын баримтал тулгуурлан, тухайн үед хоёр орны хооронд албан ёсны өргөн дэлгэр харилцаа тогтоогүй ч, тодорхой хэмжээнд харилцаж байсныг тодруулсан байна. Ялангуяа Монгол-Солонгосын харилцаа, Монголд сууж байсан солонгос хүмүүсийн үйл ажиллагааны талаарх архивын баримтуудыг олж, судалгааны эргэлтэд оруулсан нь чухал ач холбогдолтой юм.

Мөн зохиолын дэд дэвтэрт БНМАУ, БНАСАУ-ын улс төр, эдийн засаг, соёлын харилцааны түүхийг тусгахын зэрэгцээ өгүүлэн буй үеийн Солонгосын хойгийн улс төрийн байдал, Солонгосын дайн, уг дайнд БНМАУ-ын оролцооны талаар судалгааны зохиол, архивын баримтад түшиглэн нарийвчлан судалжээ.

2011 онд доктор Ж.Баттөрийн дээрх нэгэн сэдэвт зохиолыг Орчин үеийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн солонгос хэлээр хэвлүүлсэн⁸ нь уг зохиолын ач холбогдлыг өндөр үнэлсний нотолгоо юм.

МУИС-ийн Ази судлалын тэнхимийн багш Г.Эрдэнэчимэг “XIII-XIV зууны Монгол-Солонгосын харилцаанд төрийн ургийн барилдлага нөлөөлсөн нь” сэдвээр магистрын зэрэг хамгаалсны дээр дундад үеийн Монгол-Солонгосын харилцааны сэдвээр хэд хэдэн илтгэл, өгүүлэл нийтлүүлжээ.⁹

Түүнчлэн Г.Эрдэнэчимэг Солонгосын түүхийн сурах бичгийг¹⁰ Монголд анх удаа зохиосон нь-судлаач, оюутан сурагчдад нэн хэрэгтэй гарын авлага болжээ. Эдүгээ тэрээр Корйё улсын вангийн монгол хатдын үйл ажиллагааг тусгайлан судалж, докторын зэрэг хамгаалахаар бэлтгэж байна.

Судлаач Ц.Цэрэндорж 2010 онд БНСУ-д докторын зэрэг хамгаалсны¹¹ дээр Солонгосын түүх, дундад зууны Монгол-Солонгосын харилцааны асуудлаар

дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал, УБ., 2011.

⁸ 바트투르지움, 현대몽골연구원 옮김, 20세기 한국몽골관계사, KM미디어, 2011.

⁹ Г.Эрдэнэчимэг, Гуулин улсын үеийн монгол хатдын эдийн засгийн түшиг тулгуур- Эрдэм шинжилгээний бичиг, Боть 170 (1) МУИС, Гадаад хэл соёлын сургууль, УБ., 2001; Г.Эрдэнэчимэг, Юан, Корйёгийн төрийн ураг барилдлагын тухай- “Монгол, Солонгосын эрдэм шинжилгээний хамтын ажиллагааны өнөө ба ирээдүй» эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, УБ., 2010;

Г.Эрдэнэчимэг, Корйёгийн ван Чхүрийөлийн хатан Хутлуг келмишийн эдийн засгийн үйл ажиллагаа-Монгол улс БНСУ-тай дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал, УБ., 2011, Г.Эрдэнэчимэг, Корйёгийн ван Чхүнийөлийн хатан Хутлуг келмишийн улс төр - МУИС-д Солонгос судлалын салбар байгуулагдсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал, УБ., 2011.

¹⁰ Г.Эрдэнэчимэг, Солонгосын түүх I, II дэвтэр, УБ., 2006.

¹¹ 책메트 채령도르지, 14세기 후반 동아시아의 국제정세와 북원과 고려의 관계, 韓國學中央研究院 韓國學大學院 博士學位論文, 2010.

хэд хэдэн өгүүлэл нийтлүүлж¹², Солонгосын түүхийн сурвалжаас орчуулжээ¹³. Сүүлийн жилүүдэд тэрээр Монгол дахь солонгос судлал, БНСУ дахь монгол судлалын байдал, Чосонь улсын үеийн Монгол-Солонгосын харилцаа, ялангуяа Монголын түүхэнд холбогдох солонгос сурвалжийн мэдээний талаар судалгаа хийж, илтгэл¹⁴, өгүүлэл¹⁵, сурах бичиг¹⁶ нийтлүүлжээ.

Мөн МУИС-ийн Ази судлалын тэнхимийн багш Б.Ариунбайгаль XIII зууны Монгол-Солонгосын харилцааны бичгүүдийн судалгаагаар магистрын зэрэг хамгаалж, хэд хэдэн илтгэл, өгүүлэл нийтлүүлж¹⁷, эдүгээ энэ чиглэлээр докторын зэрэг хамгаалахаар суралцаж байна.

¹² Ц.Цэрэндорж, “Солонгос (Solungyus)” хэмээх нэрийн учирт - Төв Азийн нүүдэлчдийн угсаа соёл, амьдралын хэв маяг, НСИСОУХ, УБ., 2005; Ц.Цэрэндорж, Корё улсын ван, хатдын нэрийг дахин нягтлах нь - “Монгол судлал”-МУИС, МХСС-ийн эрдэм шинжилгээний бичиг, Боть XXVIII (294), УБ., 2008; Ts.체령도르지, 몽골 역사학자들의 고려사 연구 성과 - 한국을바라보는 9개의시선, 한국학중앙연구원 한국학대학원 역음, 성남, 2008; Ц.Цэрэндорж, Аюушридар хаанаас 1373 онд Корё улсын ванд илгээсэн жуу бичиг хийгээд Умард Юань, Корёгийн харилцааны асуудалд - Acta Historica, МУБИС-ийн ТНУС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл, №10, УБ., 2009; Ц.Цэрэндорж, Конминь вангийн үеийн Умард Юань, Корёгийн харилцаа- Олон улсын монголч эрдэмтний X их хурал, УБ., 2011; Ц.Цэрэндорж, Монгол-Корёгийн харилцаа тогтсон нь - Acta Historica, МУБИС-ийн ТНУС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл, №15, УБ., 2014.

¹³ Ирйён, Гурван улсын нөхсөн судар (三國遺事), орчуулсан Ц.Цэрэндорж, Ж.Гантулга, УБ., 2009;

Юү Дыггон, Пархэгийн шинжлэл, орчуулсан Ц.Цэрэндорж, УБ., 2014.

¹⁴ Ц.Цэрэндорж, Монгол дахь Солонгосын түүхийн судалгаа: Өнөөгийн байдал, хэтийн төлөв - “Монгол, Солонгосын харилцаа, хамтын ажиллагаа: Сорилт ба боломж” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, УБ., 2011.11.04; С.Цолмон, Ц.Цэрэндорж, Монголын түүхийн сурах бичигт Солонгосын талаар өгүүлсэн нь – “A Proposal for a Desirable Relationship between Korea and Mongolia” сэдэвт Монгол-Солонгосын форум, УБ., 2012.5.22; Ц.Цэрэндорж, Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхэнд холбогдох солонгос сурвалжийн зарим мэдээ - “Чин гүрэн ба монголчууд” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, УБ., 2012.9.07; Ц.Цэрэндорж, Солонгосын түүхийн сурвалж дахь ойрад хаадын тухай зарим мэдээ - “Ойрад судлал: Түүх, соёлын зүтгэлтнүүд” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, Ховд, 2012.9.20-2012.9.23; Ц.Цэрэндорж, Монголчуудын Солонгосын талаарх ойлголт -1368-1911 он- “Монгол, Солонгос хоёр орон бие биеэ хэрхэн ойлгож байсан тухай” сэдэвт Монгол-Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээний хурал, БНСУ: Соёл, 2013. 5. 09-10.

¹⁵ Ц.Цэрэндорж, Монголын Тайсун хаанаас 1442 онд Чосонь улсын Сэжон ванд илгээсэн сургах зарлигийн бичиг - Түүхийн судлал, Том. 40, УБ., 2010; Ц.Цэрэндорж, Солонгос судлалын академийн харьяа вангийн номын сан “Чансогаг”-т хадгалагдаж буй манж хэлээрх баримтын судалгаа (1725 оны баримт)- Түүхийн судлал, Том. 41-42, УБ., 2012; Ц.Цэрэндорж, БНСУ дахь Монгол судлалын өнөөгийн байдал - Шинжлэх ухаан амьдрал, 2013, № 4; Ц.Цэрэндорж, Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхэнд холбогдох солонгос сурвалжийн зарим мэдээ – CNEAS Reports 13, Чин улс ба монголчууд, Япон, Сэндай, 2014.

¹⁶ Солонгосын уламжлалт нийгмийн ноёлогч бүлэг – янбань, Соёл, 2013.

¹⁷ Б.Ариунбайгаль, Солонгос-Монгол харилцааны бичгүүд ба 1270 оны цагаан луу өдөр Гуулин улсын ван Юань улсад илгээсэн өргөх бичиг- Хавсарга хэл шинжлэл ЭШБ, Тусгай дугаар, ШУТИС, 2010; Б.Ариунбайгаль, 1270 онд Гуулин улсаас Монголд илгээсэн төрийн захидал бичгүүд, Магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС, ГХСС, УБ., 2011; Б.Ариунбайгаль, XIII зууны Монгол - Солонгосын харилцааны өрнөл ба 1270 оны хавар монголд илгээсэн захидал- “Монголчуудын угсаа гарал ба түүхийн талаарх судалгаа”, Солонгосын Монгол судлал холбоо 34 дэх удаагийн ОУЭШХ, Соёл, 2014.

Дээр нэр дурдсан судлаачдын бүтээлээс гадна бүс нутгийн түүхийг судалсан нэгэн сэдэвт зохиолуудын дотор монгол, солонгосын түүх, соёлын харилцааны асуудлыг дам хөндөн судалсан зохиолууд буй агаад тэдгээрээс Ш.Нацагдорж¹⁸, Ч.Далай¹⁹, Ц.Шагдарсүрэн²⁰, Т.Мөнхцэцэг²¹, Ж.Бор²² нарын бүтээлийг онцлон дурдаж болно.

Мөн “Монгол улсын түүх” таван боть²³, “Монгол цэргийн түүхийн товчоон”²⁴, “Монголын эзэнт гүрний гадаад харилцаа”²⁵, “Монголын Юан гүрэн” зэрэг хамтын бүтээлүүдэд хоёр орны харилцааны түүх, соёл, цэргийн түүхийн асуудлуудыг тодорхой хэмжээнд хөндөн судалсан байна.

Гэвч “Монголын эзэнт гүрний гадаад харилцаа” хамтын бүтээл (Монгол-Солонгосын харилцааны талаарх хэсгийг Б.Лхагва бичсэн)-ийг эс тооцвол солонгос судлалын мэргэжилтэй хүн бичээгүй тул эдгээр зохиолууд солонгос хэлээр буй эх сурвалж, судалгааг ашигласан, анхдагч шинжтэй судалгаа болж чадаагүй ажээ.

Түүнчлэн Монгол-Солонгосын түүх, соёлын харилцааны эрт үеэс өнөөг хүртэлхи олон талт асуудлаар Д.Цэдэв²⁶, Б.Сумьяабаатар²⁷, Ж.Болдбаатар²⁸,

¹⁸ Ш.Нацагдорж, Хубилай сэцэн, УБ., 1998.

¹⁹ Ч.Далай, Монголын түүх (1260-1388), Гудгаар дэвгэр, УБ., 1992.

²⁰ Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, УБ., 2001.

²¹ Т.Мөнхцэцэг, XIII-XIV зууны үеийн Монгол, Японы харилцаа, УБ., 2004.

²² Ж.Бор, Монголын дипломатын товчоон, УБ., 1998; Ж.Бор, Монгол хийгээд Евразийн дипломат шастир, боть I, II, УБ., 2004.

²³ Монгол улсын түүх, таван боть, УБ., 2003.

²⁴ Монгол нэргийн түүхийн товчоон, I, II боть, УБ., 1995.

²⁵ Монголын эзэнт гүрний гадаад харилцаа, Дорио дахин, олон улс судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлэв, УБ., 1995.

²⁶ Д.Цэдэв, Монгол ба Солонгосын шашин, соёлын харилцааны зарим асуудалд-Зүүн хойд Ази судлал, 1 (1), 1992.

²⁷ Б.Сумьяабаатар, Гурван ханы нутаг дахь гэрэлт хөшөөний монгол бичээс 2 - Монгол, Солонгосын хамтарсан 2-р эрдэм шинжилгээний хурал, УБ., 2001; Б.Сумьяабаатар, Самханы нутаг дахь монгол бичээсүүдийн тухай - Монгол, Солонгосын хооронд дипломат харилцаа тогтоосны 10 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал, УБ., 2000; B.Sumiyabaatar, The Mongolian-Korean correspondence relation and international Mongolianology- “The promotion of the historical and cultural community of Korea-Mongolia”, Seoul, 2010.

²⁸ Ж.Болдбаатар, Монгол, Солонгосын улс төрийн харилцаа (1991-2001) – Монгол, Солонгосын хамтарсан 2-р эрдэм шинжилгээний хурал, УБ., 2001; Ж.Болдбаатар, 1920-1930-аад оны Монгол, Солонгосын харилцаа-“БНСУ-ын тусгаар тогтнолын хөдөлгөөн ба Монгол” олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл, УБ., 2001.

А.Очир²⁹, Ц.Шагдарсүрэн³⁰, С.Цолмон³¹, Н.Хишигт³², А.Пунсаг³³ зэрэг эрдэмтэд ном бүтээл нийтлүүлжээ. Эдгээрийн дотроос Монгол-Солонгосын харилцаа Монголын түүх бичлэгт хэрхэн туссан талаар тодорхой өгүүлсэн доктор С.Цолмонгийн бүтээлийг³⁴ онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Мөн сүүлийн жилүүдэд профессор Б.Сумьяабаатарын судлан нийтлүүлсэн Хубилай хааны үеийн Монгол-Солонгосын харилцаанд холбогдох солонгос сурвалжийн мэдээний түүвэр³⁵, Монгол-Солонгосын түүхч, археологичдын холбооноос эрхлэн гаргасан 1945-1990 оны хооронд Монголын сонинд гарсан Монгол-Солонгосын харилцаатай холбоотой мэдээ, өгүүллийг эмхтгэл³⁶ зэрэг нь дундад болон шинэ үеийн Монгол-Солонгосын харилцааны түүхийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болно гэж үзэж байна.

Монгол дахь Солонгосын түүх судлалын байдлыг товч танилцууллаа. Дээрх танилцуулгаас үзэхэд өнгөрсөн болон өнөө үеийн судалгааны чиг хандлага нь гол төлөв хоёр орны харилцааны түүхийн асуудалд анхаарч байсан нь тодорхой байна. Ялангуяа дундад зууны болон шинэ үеийн Монгол-Солонгосын харилцааны асуудалд түлхүү анхаарч иржээ.

1990 оноос өмнө солонгос судлалын мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай байсан хэдий боловч зарим эрдэмтэн судлаачдын хүчин чармайлтын үр дүнд тодорхой амжилтанд хүрчээ.

Харин 1990 оноос хойш Солонгосын түүх судлал тоо, чанарын хувьд эрс дээшилсэн байна. Энэ нь Монгол улс БНСУ-тай дипломат харилцаа тогтоосноор

²⁹ А.오치르, 몽골과 한국의 관계에 대하여-고구려발해연구, 제18집, 2004.

³⁰ Ц.Шагдарсүрэн, Монгол, Солонгосын түүхэн хэлхээ холбооны асуудалд – Монгол, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 10 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал, УБ., 2000.

³¹ С.Цолмон, Монгол цэрэг Чүнжү цайзыг дайлсан нь – Хар сүлд, УБ., 2003; S.Tsolmon, Cultural exchange between Goryeo and Mongolia –“Revising Korea-Mongolia relations”, ШУА, Зүүн хойт Азийн түүхийн сангаас хамтран зохион байгуулсан хурал, УБ., 2009; S.Tsolmon, Some issues about taxation from Koryo during the Mongolian Great empire - “The promotion of the historical and cultural community of Korea-Mongolia”, Seoul, 2010.

³² Н.Хишигт, Коминтерний дорно дахины бодлого: Монгол, Солонгосын хувьсгалт коммунист байгууллагуудын үүслийн асуудалд – Монгол, Солонгосын хамтарсан 3-р эрдэм шинжилгээний хурал, УБ., 2002; N.Khishigt, A political situation in Mongolia during the Baron Ungern’s regime – Hama, 2009; Н.Хишигт, Монгол-Солонгосын харилцааны анхны алхмууд (1910-1920-нод он)–“Revising Korea-Mongolia relations”, ШУА, Зүүн хойт Азийн түүхийн сангаас хамтран зохион байгуулсан хурал, УБ., 2009.

³³ А.Пунсаг, Их Юань улсын эхэн үеийн Монгол-Солонгосын улс төрийн харилцааны зарим онцлог- Тэнгэрийн Их Юань улсын түүхэн тэмдэглэл, УБ., 2010; А.Пунсаг, Тогоонтөмөр хааны түүх хэмээх хятад сурвалж дахь Солонгостой холбогдох зарим мэдээний тухай– “Revising Korea-Mongolia relations”, ШУА, Зүүн хойт Азийн түүхийн сангаас хамтран зохион байгуулсан хурал, УБ., 2009.

³⁴ С.Цолмон, Пак Вонгил, Монгол Солонгосын харилцааны түүхийн судалгаа, Сөнгйүньгвань их сургуулийн Сөнгйүнь хятад судлалын хүрээлэн, УБ., 2014.

³⁵ Б.Сумьяабаатар, Хубилай их хааны үеийн Монгол-Солонгосын харилцаа, УБ., 2015.

³⁶ Монгол-Солонгосын харилцаа: түүх ба баримт (1945-1990), МСТАХ, УБ., 2015.

хоёр орны харилцаа бүхий л салбарт эрчимжээний шууд тусгал гэж үзэх нь зүйтэй. Монгол улсад солонгос судлалын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх болж, тэдний түрүүч нь эдүгээ Солонгосын түүх судлах үйлсэд хүчээ оргөж явна. Ийнхүү Монгол дахь Солонгосын түүх судлалд ихээхэн ахиц гарч байгаа хэдий ч судалгаа нь хоёр орны харилцааны түүхийн хүрээнээс төдий л халин гарч чадаагүй байна.

Энэ нь дараах хэдэн шалтгаанаас үүдсэн бололтой.

- Солонгос судлалын эхний шатанд цэвэр Солонгосын түүхийг сонирхон судлахад ихээхэн бэрхшээлтэй тул эхлээд өөртэйгээ хамгийн ойр сэдвийг, өөрөөр хэлбэл харилцааны түүхийг судлах нь хэнд ч ойлгомжтой хэрэг билээ.
- Солонгосын тал гадаадад буй Солонгостой хамаа бүхий баримт хэрэглэгдэхүүнийг олж илрүүлэх, судлахад гол анхаарал хандуулж ирсэн нь манай судлаачдыг харилцааны түүхийг сонгон судлахад нөлөөлсөн бололтой.
- Монголд Солонгосын түүхээр мэргэжсэн хүнийг ажиллуулах ажлын байр үндсэндээ алга байна. Тиймээс аль ч тал руу хөрвөх чадвартай байхын тулд харилцааны түүхийг сонгон судалж байна гэж үзнэ.
- Солонгос бол ханз үсгийн соёлтой ард түмэн. Гэтэл монголчууд ханз үсэг хэрэглэдэггүй. Тиймээс XX зуунаас өмнөх үеийн Солонгосын түүхийг судлахад монголчуудын хувьд багагүй бэрхшээлтэй тулгарч байна.

Цаашид Монголд Солонгосын түүхийн судалгааг хөгжүүлэх, шинэ шатанд гаргахын тулд дараах ажлыг хийх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнийг 1-рт: Монгол-Солонгосын харилцааны түүх, 2-рт: Солонгосын түүх гэсэн 2 үндсэн чиглэлд ангилан, тэдгээрийг дотор нь дараах байдлаар нарийвчлан авч үзэж болно.

- ✓ Эрт, дундад, шинэ үеийн Монгол-Солонгосын харилцааны түүхийн судалгааг гүнзгийрүүлэхийн тулд шинэ сурвалж бичиг, мэдээ баримтыг судалгааны эргэлтэд оруулах, орчуулан нийтийн хүртээл болгох шаардлагатай байна.
- ✓ Юун түрүүнд, хоёр орны харилцааны түүхэн дэх хамгийн оргил үе болох XIII-XIV зууны үеийн харилцааны түүхийг нарийн тусгасан эрдэм шинжилгээний бүтээлийг зохион гаргах шаардлагатай байна. Улмаар үүнийг цааш үргэлжлүүлэн XV-XX зууны эхэн хүртэлх харилцааны түүхийг судалсан эрдэм шинжилгээний бүтээл туурвиж, энэ үед холбогдох сурвалж хэрэглэгдэхүүнийг судалгааны эргэлтэд оруулах нь зүйтэй.

- ✓ Монгол-Солонгосын харилцааны түүх бол судалгааны нэг чухал чиглэл мөн боловч, үүний зэрэгцээ цэвэр Солонгосын түүхийг судлахад бас анхаарал хандуулах хэрэгтэй байна. Солонгосын түүхийн судалгааг хөгжүүлбэл түүнийг дагалдан Монгол-Солонгосын харилцааны түүхийг улам нарийвчлан судлах боломж бас нээгдэх болно.
- ✓ Солонгосын түүхийг судлахын тулд эхлээд түүний бат бэх үндэс суурийг тавих хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, Солонгосын түүхийн гол сурвалжуудыг монгол хэлээр орчуулан, эрдэм шинжилгээний зүүлт тайлбартай хэвлэн нийтлүүлж, үүн дээрээ үндэслэн судалгааг өргөжүүлэх шаардлагатай байна. Хэрэв энэ ажлыг хийхгүй бол Монгол дахь Солонгосын түүх судлал үндэсгүй мод мэт хэврэг болох аюултай.
- ✓ Солонгосын түүхийн үе бүрээр дэлгэрэнгүй сурах бичиг бичих нь зүйтэй. Энэ нь олон нийт төдийгүй, судлаачдад тустай ажил болно.